



ШИНЭ ҮЕ СУРГУУЛЬ /ЕЕ 2021/

СУДАЛГААНЫ ЭСЭЭ ХИЧЭЭЛИЙН ГАРЫН АВЛАГА



СУДАЛГААНЫ ЭСЭЭ ГАРЫН АВЛАГА

Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан гарын авлага



Шинэ Үе Сургууль

2020-2022

Ай Би хөтөлбөрийн эрхэм зорилго

Ай Би хөтөлбөр нь мэдлэг чадвартай, сонирхон судалдаг, хүн төрөлхтний өв уламжлал, ёс заншил, хэл соёлыг хүндлэн дээдэлж эх дэлхийн энх тайвныг эрхэмлэдэг, илүү сайхан ертөнцийг бүтээж чадах шинэ залуу үеийг бэлдэхийг эрхэм зорилгоо болгодог. Бид олон улсын байгууллага, засгийн газруудтай хамтран ажиллаж, олон улсын жишигт нийцсэн боловсролын хөтөлбөр боловсруулж, шударга, нягт шалгах үнэлгээний аргачлалыг улам бүр хөгжүүлсээр байна. Энэхүү хөтөлбөрөөр суралцаж буй хүүхэд бүр идэвхтэй, хүсэл тэмүүлэлтэй, хүн бүрийн онцлог зан чанарыг ойлгон хүндэтгэж чаддаг, насан туршидаа сурч боловсрох чадвартай иргэн болон төлөвшдөг.

Шинэ Үе сургуулийн эрхэм зорилго

Бид шинэ үеийнхнийг

Халамжтай

Хариуцлагатай

Хүнлэг

Хичээнгүй

Эрүүл чийрэг

Эрдэм боловсролтой

Эх хэл өв уламжлалаа хайрлан хамгаалдаг

Энэ дэлхийн улс үндэстэн бүрийн ёс заншил ахуй соёлыг хүндлэн дээдлэх иргэн болгож төлөвшүүлнэ.

IB дипломын хөтөлбөрийн зохицуулагч: Т.Ханджав

Утас: +976 91117811

Цахим шуудан: khandjav@shineue.edu.mn

Оффис: Шинэ үе сургууль, Сүхбаатар дүүрэг, UNESCO гудамж-12, АйБи Оффис

Судалгааны эсээ хичээлийн зөвлөгч багш: Б.Мөнхбаяр

Утас: +976 8881 3160

Цахим шуудан: munkhbayar@shineue.edu.mn

Оффис: Шинэ үе сургууль, Сүхбаатар дүүрэг, UNESCO гудамж-12, АйБи Оффис

“Ай Би” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар

Эх дэлхийгээ энх тайван байлгаж, одоо байгаагаас нь илүү сайхан ертөнцийг бий болгохын тулд хүнлэг чанараа танин мэдэж, энэ дэлхий ертөнцийг хамгаалах хамтын үүргээ ухамсарлан ойлгох чадвартай олон улсын сэтгэлгээтэй хүмүүс болгон хөгжүүлэхэд “Ай Би” хөтөлбөрийн эрхэм зорилго оршино.

“Ай Би ” хөтөлбөрт суралцагчийн эзэмших 10 шинж чанар:

СОНИУЧ Өөрсдийн сонирхсон зүйлсээ лавлан асуух, судлан шинжлэх чадвартай, аливаа зүйлд тэмүүлэлтэй, үргэлж суралцаж, хөгжих чадвартай иргэн болон төлөвшдөг.

МЭДЛЭГТЭЙ Тэд бүс нутагтаа болон олон улсад тулгамдсан асуудлын ойлголт, санаануудыг нээн олж чаддаг. Үүний үр дүнд тэрхүү ойлголт, санаа, асуудлынхаа талаар өргөн болоод тэнцвэртэй ойлголттой болж, гүн гүнзгий мэдлэг олж авч чаддаг. Олон талын мэдлэгтэй, түүнийгээ амьдралд хэрэглэх чадвартай иргэн болж төлөвшдөг.

ХЭРСҮҮ Нарийн төвөгтэй асуудлуудад дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй шийдвэр гаргахдаа шүүмжлэлт бүтээлч сэтгэлгээний чадварыг ашигладаг. Энэ нь тэднийг илүү хэрсүү ухаантай болгон хөгжүүлдэг.

ХАРИЛЦАГЧ Бусадтай илүү нээлттэй өөртөө итгэлтэй харилцаж, бусдыг ойлгож, анхааралтай сонсож тэдэнтэй хамтран ажиллах чадвартай иргэн болон төлөвшдөг.

ЗАРЧИМЧ Аливаа зүйлд зарчимч, шударга ханддаг, ёс зүйтэй, хууль дүрмийг чанд сахидаг, хүмүүсийн нэр төр ба эрхийг хүндэтгэж, өөрсдийн үйлдэл, тэдгээрийн үр дагавруудад хариуцлага хүлээж чаддаг иргэн болж төлөвшдөг.

НИЙТЭЧ Өөрсдийн соёл, бусдын үнэт зүйлс, уламжлалыг хүндэлж, бодитойгоор үнэлэн дүгнэдэг, юмсыг олон талаас харах чадвартай, туршлагаасаа суралцаж өсөн дэвжихэд бэлэн байдаг иргэдийг бэлддэг.

ХАЛАМЖТАЙ Өөрсдийгөө бусдын оронд тавьж, бусдыг энэрч, хүндэтгэдэг, бусдын амьдрал болон хүрээлэн буй орчинд эерэг өөрчлөлт авч ирж чаддаг иргэн болон төлөвшдөг.

ШИЙДВЭРТЭЙ Аливаа тодорхойгүй зүйлд шийдэмгий хандаж, шинэ шинэлэг санааг судлахын тулд бие даан болон хамтран ажиллах чадвартай, сорилт бэрхшээл, өөрчлөлтийн өмнө бэлэн зогсож чаддаг, хөрвөх чадвар сайтай иргэн болон төлөвшдөг.

ТЭНЦВЭРТЭЙ Өөрсдийн болон бусдын сайн сайхан зүйлсийн төлөө оюун ухаан, бие бялдар, болон сэтгэл хөдлөл зэрэг амьдралынхаа янз бүрийн төлөвийг тэнцвэржүүлэхийн чухал ач холбогдлыг ойлгодог, бусад хүмүүс болон амьдарч буй ертөнцтэйгөө харилцан хамааралтайгаа хүлээн зөвшөөрдөг уян хатан иргэн болон төлөвшдөг.

ЭРГЭЦҮҮЛЭГЧ Аливаа зүйлсийн мөн чанарыг эргэцүүлэн бодож, юмсын сайн муу, үнэн зөвийг ялган таньж ухаалгаар шийдвэрлэж чаддаг.

АГУУЛГА

АГУУЛГА	3
Судалгааны эсээний мөн чанар	5
Судалгааны эсээний сэдэв	5
Судалгааны эсээний сэдэв	6
Судалгааны эсээний судалгааны ажлыг судлах, төлөвлөх, бичих	6
Төлөвлөх ба бичих	8
Гарчгийн хуудас	8
Агуулгын хуудас	8
Эсээний үндсэн хэсэг	9
Дүгнэлт	9
Ном зүй	9
Зураг	9
Хавсралт	10
Судалгааны эсээний эргэцүүлэмж	10
Судлаачийн эргэцүүлэмжийн орон зай (RRS)	12
Сурлагын шударга журам	16
Судалгааны эсээний үнэлгээ	16
Шалгуур А: Чиглэл ба арга зүй	16
Шалгуур Б: Мэдлэг ба ойлголт	17
Шалгуур С: Шүүмжлэлт сэтгэлгээ	17
Шалгуур D: Бичвэр	17
Шалгуур E: Оролцоо	17
Ерөнхий шалгуурын хянах хуудас	17
Судалгааны эсээ/Мэдлэгийн онолын онооны матриц	18
Ашигласан материалын жагсаалт	19

Эрхэм хүндэт эцэг эх, асран хамгаалагчид аа!

Олон улсын бакалаврын дипломын хөтөлбөрийн замналыг сонгож, хүүхдээ олон улсын бакалаврын дипломын хөтөлбөрт элсүүлсэнд тань баярлалаа!

Ирэх жил хагасын хугацаанд суралцагчид АйБи хөтөлбөрт заавал судлах шаардлагатай цөм хөтөлбөрийн нэг болох Судалгааны Эсээ (EE) бичих шаардлагатай болно.

Судалгааны эсээгээ судалж, гүйцэтгэх нь суралцагчдад Шинэ Үе сургуульд сурч боловсроход илүү их туршлага хуримтлуулах боломжийг олгоно. Энэхүү эсээ нь суралцагчдад сонирхсон судлагдахууныхаа талаар шүүмжлэлт судалгаа хийх боломжийг олгоход зориулагдсан бөгөөд судалгааны эсээний төслөөс олж авсан туршлага, ур чадвар нь суралцагчдыг их сургууль болон түүнээс цааш насан туршийн боловсрол эзэмшихэд нь хөтлөх болно. Бараг бүх их сургуулийн хичээлүүд судалгааны эсээтэй адил эрдэм шинжилгээний ажил хийхийг шаарддаг.

Суралцагчдад диплом горилогчийн хувьд гүйцэтгэх олон үүрэг, даалгавар байгаа бөгөөд судалгааны эсээний хувьд үүнд бусад шаардлагуудын нэгэн адил тууштай, идэвхтэй хандах нь нэн чухал юм.

Сурагцагчид судалгааны эсээний ерөнхий судлагдахууныг сонгосны дараа судалгааны эсээний зааварлагч багшыг сонгоно. Энэ багш нь суралцагчийн судлахаар сонгосон судлагдахууны талаар гүнзгий мэдлэгтэй байх ёстой ба Шинэ үе сургуулийн аль ч багш зааварлагч болж болно.

Энэхүү гарын авлагыг судалгааны эсээний үйл явцад туслах зорилгоор бүтээсэн болно.

Бид танд туслахдаа баяртай байх болно!

Хүндэтгэсэн,

Т.Ханджав

АйБи дипломын хөтөлбөрийн зохицуулагч

Судалгааны эсээний мөн чанар

АйБи дипломын хөтөлбөрийн судалгааны эсээний гарын авлагын дагуу “Судалгааны эсээ нь суралцагчдын хувьд өөрийн сонирхсон судлагдахууныг гүнзгийрүүлэн судлах онцгой боломж юм. Энэ нь суралцагчдад сонгосон сэдвийнхээ дагуу өөрсдийн хүсэл тэмүүлэл, урам зориг, оюуны зураглал эсвэл бүтээлч арга барилыг харуулах боломжийг олгодог бие даан бичсэн судалгааны ажлын хэлбэр юм. Дэлхий судлалын хувьд судалгааны эсээний иймэрхүү сэдвүүд асуудлын тодорхой хэсэгт голдуу төвлөрсөн гүн судалгаа шинжилгээнээс эхлүүлээд дэлхий нийтэд тулгамдсан асуудлуудад авч буй хариу арга хэмжээг шүүмжлэлтэйгээр үнэлэх хүртэл янз бүр байж болно.

Суралцагчид эрдэм шинжилгээний ажил хэлбэрээр дамжуулж судалгаа, шүүмжлэлт сэтгэлгээ, хувийн зохион байгуулалт зэрэг чухал хөрвөх чадваруудаа хөгжүүлдэг. Судалгааны үйл явцад оролцоо болон эргэцүүлэмжид онцгойлон анхаарч, сурагчийн оюун санааны болон хувь хүний төвшинд хийсэн шинэлэг туршлагыг цохон тэмдэглэж, суралцагчийн хувьд хэрхэн өөрчлөгдөж, энэ нь судалгааны эсээнд нь хэрхэн нөлөөлснийг тодотгодог.” (Судалгааны эсээ гарын авлага, 2017)

Судалгааны эсээ нь товчхондоо бол:

- дипломын хөтөлбөрийн бүх суралцагчид заавал судлах ёстой
- гадаад шалгалтаар үнэлж, мэдлэгийн онолын үнэлгээтэй хослон АйБи дипломын нийлбэр онооны гурван оноог бүрдүүлдэг
- сурагчийн сонгосон сэдвээр судалгааны эсээний зааварлагчтай хамтарсан бие даасан судалгаа/шинжилгээний ажил хийдэг
- ихэвчлэн дипломын хөтөлбөрийн хүрээнд судлаж буй зургаан сэдвийн нэг дээр бичдэг. Гэхдээ суралцагч хүсвэл тухайн сургуулиас санал болгоогүй дипломын хөтөлбөрийн хичээлийг сонгож болно
- Нийт 4000-аас ихгүй үгтэй, 500-аас илүүгүй үгтэй эргэцүүлэмжийн маягтыг хавсаргасан удаан хугацаанд бичсэн албан ёсны эрдэм шинжилгээний бичвэрийн ажил байна
- Дипломын хөтөлбөрийн туршид суралцагчдын тасралтгүй хийсэн ажлын үр дүн

Судалгааны эсээний сэдэв

Аливаа сэдвийг сонгохын өмнө судалгааны эсээнийхээ судлагдахууныг эхлээд тодорхойлсон байх хэрэгтэй. Тухайн судлагдахууны багш нь судалгааны эсээний зааварлагч байх юм.

Суралцагч нь Шинэ Үе сургуулийн дипломын хөтөлбөрөөс санал болгосон аль нэг сэдвээр судалгааны эсээ бичиж болно. Боломжит сэдвүүд нь:

<i>Бүлэг 1: Хэл, уран зохиол судлал</i>	Монгол хэл: Уран зохиол
<i>Бүлэг 2: Хэд эзэмшилт</i>	Англи хэл ахисан шат
<i>Group 3: Individuals and Societies</i>	Бизнес менежмент Түүх
<i>Бүлэг 4: Байгалийн шинжлэх ухаан</i>	Биологи Хими Физик
<i>Бүлэг 5: Математик</i>	Математик
<i>Бүлэг 6: Урлаг ба Сонголтод хичээл</i>	Бизнес менежмент Түүх Биологи Хими Физик

Мөн Шинэ Үе сургуулийн санал болгодоггүй хичээлээр сэдэв сонгож болно. Энэ тохиолдолд суралцагч судалгааны эсээний зааварлагчаа тодруулахын тулд дипломын хөтөлбөрийн зохицуулагчтай зөвлөлдөх хэрэгтэй.

Судалгааны эсээний сэдэв

Суралцагчид сэдвээ сонгож эхлэх үед дараах асуултууд тустай байж болох юм.

- Миний сэдэв ганцхан судлагдахууны хүрээнд багтдаг уу?
- Миний сэдэв 4000 үгэнд багтаан үр дүнтэйгээр тайлбарлахад хангалттай тодорхой байх уу?
- Би аль хэдийн мэддэг байсан сэдвээрээ бичиж байна уу?
- Миний сэдвийн талаар хангалттай мэдээлэл байна уу?
- Би сэдэв дээрээ олж мэдсэн мэдээллээ боловсруулах боломжтой юу?

Суралцагчид онгосон судлагдахууныхаа хүрээнд дор хаяж 3 сэдвийн талаар бодож, судалгааны эсээний зааварлагч, дипломын хөтөлбөрийн зохицуулагчтай зөвлөлдөж, судалгаа хийх, үр дүнг танилцуулахад тохиромжтой сэдвийг сонгоно.

Судалгааны эсээний судалгааны ажлыг судлах, төлөвлөх, бичих

Судалгааны эсээг судлахдаа суралцагчид дараах зүйлсийг хийх хэрэгтэй.

- Үнэлгээний шалгуур үзүүлэлт болон судалгааны эсээний гарын авлага дээрх холбогдох судлагдахууны удирдамж, АйБи хөтөлбөрийн судлаачийн ёс зүйн удирдамж, амьтан дээр хийх туршилт гэх мэт холбогдох бусад журмуудыг унших
- Судлаачийн эргэцүүлэмжийн орон зайг (RRS) шинээр үүсгэж, үүнийг судалгааны эсээний явцын гол төлөвлөлт болон эргэцүүлэмжийн хэрэгсэл болгон ашиглах
- Сонгосон сэдвийнхээ талаар дэлгэрэнгүй унших

- Урьдчилсан судалгааны асуултыг боловсруулах. Боломжтой бол судалгааны асуултад АйБи хөтөлбөрийн зааварчилгааны нэршлийг оруулахыг хичээх. Дараах хүснэгт нь үр дүнтэй судалгааны асуулт гаргахад тусална (мэдээллийг ESM сургуулийн судалгааны эсээ гарын авлагаас авав).

Судлагдахуун	Үндсэн Судалгааны Асуулт	Илүү сайн Судалгааны Асуулт
Англи хэл	“Гэрэлт цамхаг”-г эмэгтэйчүүдийг хэрхэн төлөөлдөг вэ?	Виржиниа Вүүлф эмэгтэйчүүдийн дуу хоолой, сэтгэлгээг "Гэрэлт цамхаг"-г хэрхэн төлөөлж, ямар нөлөө үзүүлдэг вэ?
Бизнес менежмент	Уолт Дисней компани нь Шанхай Диснейн амралтын газарт ажилд авах болон сургалтын бодлого, журмаа хятадын хөдөлмөрийн тухай хууль, соёлын хэтийн төлөвийн ялгааг харгалзан өөрчлөх хэрэгтэй юу?	Уолт Дисней компани Шанхай Дисней амралтын газар дахь хүний нөөцийн бодлогоо өөрчлөх хэрэгтэй юу?
Математик	Математик нь од, хиймэл дагуул ашиглан навигацид хэрхэн тусалдаг вэ?	Бид одоор баримжаалдаг байхад математик, ялангуяа геометр нь навигацид ямар үүрэг гүйцэтгэж байсан бэ? Хүний гараар бүтээсэн хиймэл дагуултай болсон байхад энэ нь одоо ч тодорхой үүрэг гүйцэтгэсээр байна уу?

- Судалгааны эсээний зааварлагчтайгаа хамт өөртөө сургууль болон АйБи хөтөлбөрийн шаардлагыг хангах боломжтой эцсийн хугацааг тогтоо
- Судалгаа хийх ба бичих үйл явцын төлөвлөгөөг гарга. Үүнд цагийн хуваарийг багтаасан байх ёстой
- Судалгааныхаа эх сурвалж материалыг хэрхэн, хаанаас цуглуулахаа тодорхойлж эхэл
- Эсээний судлагдахуунд тохирсон академик ишлэлийн ямар системийг ашиглахаа тодорхойл (Шинэ Үе сургууль нь МЛА хэв маягийг ашигладаг - <https://owl.english.purdue.edu/owl/resource/747/01/>)
- Эсээний бүтцийг төлөвлөх. Судалгаа шинжилгээ өргөжихийн хэрээр энэ өөрчлөгдөж болзошгүй боловч чиг баримжаатай байх нь ашигтай
- Судалгаагаа хий

Судалгаа хийх ба бичих үйл явцын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны эсээний гарын авлагын 72-78-р хуудаснаас үзнэ үү.

Төлөвлөх ба бичих

Судалгааны эсээний гарын авлагын дагуу бүх судалгааны эсээний эцсийн хувилбарт дараах зургаан бүрэлдэхүүн хэсгийг багтаасан байх ёстой.

- 1) Гарчгийн хуудас
- 2) Агуулгын хуудас
- 3) Оршил
- 4) Эсээний үндсэн хэсэг
- 5) Дүгнэлт
- 6) Ном зүй (ашигласан материал)

Судалгааны эсээг дараах байдлаар бичнэ.

- (Бүлэг 1) “Монгол хэл: Уран зохиол”-оос бусад судлагдахуун дээр англи хэлээр байна
- тухайн сэдвийг сонгосон судлагдахуунд тохирсон тодорхой, зөв, албан ёсны хэв маягтай байх.

Судалгааны эсээний бүх шаардлагыг хангаж, хугацаанаас хоцрохгүй байхын тулд нэмэлт цаг гаргах боломжтойгоор нь зуны улиралд судалгааны эсээ дээрээ үргэлжлүүлэн ажиллахыг бидний зүгээс зөвлөдөг.

Гарчгийн хуудас

- Гарчгийн хуудсанд зөвхөн дараах мэдээллийг багтаасан байх ёстой.
- эсээний гарчиг
- судалгааны асуулт
- эсээ бичихээр бүртгүүлсэн судлагдахуун (хэрэв энэ нь хэлний эсээ бол аль ангилалд багтаж буйг дурдах; хэрэв дэлхий судлалын эсээ бол сэдэв болон ашигласан хоёр судлагдахууныг мөн дурдана)
- үгийн тоо

Сургуулийн нэр болон суралцагчийн нэр гарчгийн хуудсан дээр эсвэл хуудасны толгойд оруулахгүй байхыг анхаарна уу. Учир нь бүтээлийг нэргүйгээр үнэлдэг.

Агуулгын хуудас

Агуулгын хуудсыг судалгааны эсээний эхэнд оруулах ёстой бөгөөд бүх хуудсыг дугаарласан байх ёстой.

Индекс хуудас заавал оруулах шаардлагагүй бөгөөд хэрэв оруулсан бол түүнийг байхгүй мэт үзэх болно гэдгийг анхаарна уу.

Оршил

Оршил нь уншигчдад тухайн эсээнээс юу хүлээж байгааг хэлж өгөх ёстой. Оршил нь

эсээний гол анхаарал татаж буй асуудал, судалгааны ажлын цар хүрээ, ялангуяа ашиглах эх сурвалжуудын заалт, маргаантай асуудлын талаарх ойлголтыг уншигчдад тодорхой болгох ёстой.

Эсээний үндсэн хэсэг

Энэ бол судалгааны эсээний гол хэсэг юм. Үүнийг үндэслэлтэй асуудал хэлбэрээр танилцуулах хэрэгтэй. Гол хэсэг нь эсээний сэдвээс хамаарч харилцан адилгүй байдаг боловч асуудал үүсэхийн хэрээр холбогдох ямар нотолгоо, хаанаас, хэрхэн олж, гол асуудлыг хэрхэн дэмжиж байгаа нь уншигчдад ойлгомжтой байх ёстой.

Эсээний үндсэн хэсэг дууссаны дараа оршил болон дүгнэлтийг эцэслэн гаргах боломжтой.

Судалгааны асуудалд чухал ач холбогдолтой аливаа мэдээллийг хавсралт, хөл/тайлбар хэсэгт оруулах ёсгүй. Шалгагч нь тэмдэглэл эсвэл хавсралтуудыг уншихгүй учир бүрэн гүйцэд бус эсээ нь үнэлгээний шалгуурыг хангахааргүй болох болно.

Дүгнэлт

Дүгнэлтэд хүрсэн зүйл, үүнд хязгаарлалт болон шийдэгдээгүй бүх асуултын тэмдэглэл орно. Та олж мэдсэн зүйл дээрээ үндэслэн эсээний туршид дүгнэлт хийж болох боловч эцэст нь эцэслэн нэгтгэсэн дүгнэлт байх нь чухал юм. Энэхүү дүгнэлт нь тавьсан судалгааны асуулттай холбоотой байх ёстой.

Ном зүй

Суралцагч бичиж эхэлсэн даруйдаа өөрийн сонгосон академик ишлэлийн хэв маягыг (Шинэ үе сургуулийн хувьд MLA) ашиглах хэрэгтэй. Ингэснээр тухайн суралцагч ишлэл оруулахаа мартаж магадлал бага байх болно. Мөн энэ нь хамгийн сүүлд нь ишлэл нэмж оруулахаас хялбар байдаг.

Зураг

Илтгэл, ерөнхий цэгцтэй байдал нь чухал бөгөөд хэрэв зураг зэрэг дүрслэх материал оруулсан бол зөв байрлуулах болон үр дүнтэй ашиглах нь чухал юм. График, диаграмм, хүснэгт, оюуны зураглал нь тодорхой тайлбартай (label), хялбархан ойлгогдохоор байгаа тохиолдолд л үр дүнтэй байдаг.

Шалгагч оюуны зураглал, схем, диаграм, эсвэл зурагны ач холбогдлыг ойлгож буйг баталгаажуулахын тулд аливаа тайлбар (labelling) нь хамгийн бага мэдээллийг агуулсан байх ёстой. Үүнд дургал оруулахгүй байх ёстой, учир нь энэ нь эсээ хэлэлцүүлгийн нэг хэсэг гэж тооцогдох бөгөөд ингэснээр үгийн тоонд орно.

Судалгааны эсээд оруулсан бүх ийм материал нь тексттэй шууд холбоотой байх ёстой бөгөөд шаардлагатай бол мэдэгдсэн байх ёстой. Гэрэл зураг болон бусад зургийг ашиглахдаа зөвхөн тайлбар тэмдэглэгээ бичсэн байх бөгөөд судалгааны эсээд заасан тодорхой санааг дүрслэн харуулсан тохиолдолд л ашиглах боломжтой.

Хэт их зураг ашиглах нь эсээний хэлэлцүүлгийг сарниулж болзошгүй тул зураг чимэглэлийг болгоомжтой ашиглахыг бид зөвлөдөг. Эдгээр нь эсээний аргументийн аль

нэг хэсэгт хамааралтай ба тохиромжтой байх тохиолдолд л ашиглагдах хэрэгтэй.

Хавсралт

Хавсралт нь судалгааны эсээний зайлшгүй хэсэг биш бөгөөд эсээг үнэлэхдээ шалгагчид эдгээрийг уншихгүй ба тэдгээрийн доторх аливаа мэдээллийг ашиглахгүй. Суралцагч эсээнийхээ дүн шинжилгээ, хэлэлцүүлэг, үнэлгээтэй шууд хамаарал бүхий мэдээллийг үндсэн хэсэгт нь багтаасан байх ёстой.

Дараах тохиолдлоос бусад тохиолдолд хавсралтаас зайлсхийх хэрэгтэй:

- асуулга эсвэл ярилцлагын асуултын загвар
- зөвшөөрлийн бичгийн загвар
- Бүлэг 1, 1-р ангиллын эсээ: шүлэг, богино өгүүллэгийн хуулбар (гурваас ихгүй хуудас)
- Бүлэг 1, 3-р ангиллын эсээ: сонины хэсгүүд, зар сурталчилгаа, илтгэлийн тэмдэглэл
- хэл эзэмшилт, 1 ба 2-р ангилал: сонин, сурталчилгааны хэсгүүд, хэлсэн үгсийн тэмдэглэл гэх мэт.
- хэл эзэмшилт, 3-р ангилал: шүлэг, богино өгүүллэгийн хэсэг, хэсэг (гурав хүрэхгүй хуудас)
- өмнө нь ашиглаж байсан хөндлөнгийн зөвлөгчийн захидал
- туршилтат шинжлэх ухааны боловсруулаагүй мэдээлэл эсвэл статистик хүснэгтүүд (үүнд дүн шинжилгээ, дүгнэлт ороогүй байх ёстой).

Суралцагч хавсралтад дурдсан материалыг олон дахин дурдах шаардлагагүй ба энэ нь эсээний үргэлжлэлийг тасалдуулж болзошгүй, мөн шалгагчид тэдгээрийг харах шаардлагагүй.

Судалгааны эсээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Судалгааны эсээ гарын авлагын 79–84-р хуудаснаас үзнэ үү.

Судалгааны эсээний эргэцүүлэмж

Суралцагч заавал 3 удаа эргэцүүлэл хийх бөгөөд зааварлагчтайгаа долоо хоног бүр тогтмол уулзалт хийх хэдий ч суралцагч тусламж хэрэгтэй үедээ судалгааны эсээтэй холбоотой асуулт асууж болно. Эргэцүүлэмжийн ганцаарчилсан уулзалтын үеэр суралцагч судалгааны эсээний судалгаа болон бичих үйл явцын талаар 150-175 үгтэй эргэцүүлэмж бичиж оруулах шаардлагатай болно.

Эргэцүүлэмжийн ганцаарчилсан уулзалт	Тодорхойлолт
<p>Анхны эргэцүүлэмжийн ганцаарчилсан уулзалт (дипломын хөтөлбөрийн 1 дэх жилийн хавар)</p>	<p>Суралцагч RRS (судлаачийн эргэцүүлэмжийн хүснэгт) дээрээ сэдвийг судлах эхний жишээ, боломжит эх сурвалж, арга зүй, судалгааны урьдчилсан асуултууд болон асуудалд хандах хувь хүний хариу арга хэмжээг оруулах шаардлагатай.</p> <p>Зааварлагчтайгаа хамт анхны эргэцүүлэмжийн ганцаарчилсан уулзалтад оролцохдоо суралцагч RRS-д оруулсан тэмдэглэлээ хэлэлцүүлгийн үндэс болгон ашиглахаас гадна судалгааны явцад гаргасан ахиц амжилтаа харуулах боломжтой.</p>
<p>Завсрын хугацааны эргэцүүлэмжийн ганцаарчилсан уулзалт (дипломын хөтөлбөрийн 2 дахь жилийн 9-р сард)</p>	<p>Бодол санаагаа хөгжүүлж, маргаан дэвшүүлж, зааварлагчаасаа асууж болох бүх зүйлийг асуух.</p> <p>Энэ үе шатанд RRS (судлаачийн эргэцүүлэмжийн хүснэгт)-д ойлголтын хариу үйлдэл, судалгааны эсээг дуусгах хугацаанд гарсан ахиц дэвшил, мэтгэлцээнээс гарч болзошгүй үр дүн, тулгарсан бэрхшээл болон тэдгээрийг даван туулсан стратеги зэргийг багтааж болно.</p>
<p>Эцсийн эргэцүүлэмжийн ганцаарчилсан уулзалт - аман илтгэл (дипломын хөтөлбөрийн 2 дахь жилийн 2-р сард)</p>	<p>Судалгааны эсээний явцыг дуусгасны дараа явагдах эцсийн эргэцүүлэмжийн ганцаарчилсан уулзалтын үе нь эсээг нэгтгэн дүгнэх үйл явцын талаар хэлэлцэх суурь болж өгдөг.</p> <p>Суралцагч тухайн сэдвийн талаар сурч мэдсэн зүйл, дагаж мөрдсөн судалгааны үйл явц, өөрийн сурч мэдсэн зүйлээ харуулахаас гадна шинээр сурч мэдсэн зүйлсээ тоймлон харуулах боломжтой.</p> <p>Хамгийн чухал нь эцсийн эргэцүүлэмжийн ганцаарчилсан уулзалтын үеэр RRS (судлаачийн эргэцүүлэмжийн хүснэгт) нь тухайн ажилд хамааралтай ач холбогдлыг суралцагчид тодотгож, эцэст нь зааварлагчийн тайланд тусгаж оруулна.</p>

Судалгааны эсээний удирдамжийн дагуу суралцагч нь оюуны өсөлт, шүүмжлэлт ба хувь хүний хөгжил, санаачилга ба бүтээлч байдлын нотолгоог үзүүлнэ. Үүнийг RRS ашиглах замаар хялбаршуулсан байна.

Эргэцүүлэмжийг дэлгэрэнгүй бичих нь суралцагчийн олж авсан ур чадварыг харуулна:

- шүүмжлэлт сэтгэлгээ
- шийдвэр гаргах
- ерөнхий судалгаа
- төлөвлөлт
- ашигласан материалын жагсаалт, эшлэл
- судалгааны тодорхой арга зүй
- цаг төлөвлөлт.

Төлөвлөлт, явц бөглөх маягт (RPPF - Хавсралт 1)-д эргэцүүлэмжийг баримтжуулсан байх ёстой.

Судлаачийн эргэцүүлэмжийн орон зай (RRS)

Шийдвэр гаргах үйл явцыг илүү тодорхой илэрхийлэх, ойлгомжтой болгохын тулд RRS-ийг ашиглахыг зөвлөдөг. RRS(судлаачийн эргэцүүлэмжийн хүснэгт) нь биет эсвэл виртуал туслах хэрэгсэл байж болохуйц хувийн суралцахуйн орчин юм. Энэ бол таны уншиж, бичиж, бодож байгаа зүйлийнхээ талаар эргэцүүлэн бодох боломжтой орон зай юм. RRS-ийг (судлаачийн эргэцүүлэмжийн хүснэгт) ашигласнаар зааварлагч нартайгаа хийх эргэцүүлэмжийн ганцаарчилсан улзалталтын бэлтгэлээ базаахад туслах бөгөөд болох хэлэлцүүлгийг мэдээлэх болно. Эргэцүүлэмжийн ганцаарчилсан уулзалтад бэлтгэхийн тулд суралцагч өөрийн RRS-ийг (судлаачийн эргэцүүлэмжийн хүснэгт) дараах зорилгоор ашиглаж болно:

- эргэцүүлэмжээ бичиж тэмдэглэх
- гэрэл зураг, сонины хайчилбар, твиттер хуудас, блог гэх мэт дүрслэлүүдэд хариу үзүүлэх
- суралцагчийн хичээлийн чиглэлээр, ТОК хичээлүүд эсвэл Дипломын хөтөлбөрийн бусад асуудлуудад гарч болох асуултуудад хариулах
- оюуны зураглал үүсгэх
- гарч ирж буй асуултуудыг тэмдэглэх.

RRS-д (судлаачийн эргэцүүлэмжийн хүснэгт) бүртгэгдсэн ойлголт, мэдээлэл нь эсээ, эргэцүүлэмж, RPPF-ийн үндэс суурийг бүрдүүлж, өөрийн ажлыг шууд илэрхийлэх боломжийг олгодог. Зааварлагчтайгаа ярилцахдаа суралцагч RRS-аас иш татах ёстой. Эдгээр эргэцүүлэмжийг ганцаарчилсан уулзалтад ишлэлийн гол санаа болгон ашигласнаар суралцагч нь:

- төлөвлөлтөө харуулах
- сурч байгаа зүйлийнхээ талаар ярилцах
- өөрийн ахиц дэвшлийг үнэлэх боломжтой болох юм.

EE/RPPF

For first assessment in 2018

Page 1 / 3



International Baccalaureate®
Baccalauréat International
Bachillerato Internacional

Candidate personal code:

Extended essay - Reflections on planning and progress form

Candidate: This form is to be completed by the candidate during the course and completion of their EE. This document records reflections on your planning and progress, and the nature of your discussions with your supervisor. You must undertake three formal reflection sessions with your supervisor: The first formal reflection session should focus on your initial ideas and how you plan to undertake your research; the interim reflection session is once a significant amount of your research has been completed, and the final session will be in the form of a viva voce once you have completed and handed in your EE. This document acts as a record in supporting the authenticity of your work. The three reflections combined must amount to no more than 500 words.

The completion of this form is a mandatory requirement of the EE for first assessment May 2018. It must be submitted together with the completed EE for assessment under Criterion E.

Supervisor: You must have three reflection sessions with each candidate, one early on in the process, an interim meeting and then the final viva voce. Other check-in sessions are permitted but do not need to be recorded on this sheet. After each reflection session candidates must record their reflections and as the supervisor you must sign and date this form.

First reflection session

Candidate comments:

Date:

Supervisor initials:



Interim reflection

Candidate comments:

Date:

Supervisor initials:

Final reflection - Viva voce

Candidate comments:

Date:

Supervisor initials:



Supervisor comments:



Сурлагын шударга журам

Судалгааны эсээ дээр ажиллахдаа судалгааны бүх дадлага нь академик сурлагын шударга журмын зарчмуудыг тусгасан байх нь маш чухал юм. Эсээ нь уншигчдад ишлэл, санаа, үзэл бодлын дэлгэрэнгүй эх сурвалжийг текст хэлбэрээр эсвэл зүүлт хэлбэрээр оруулж болохуйц ишлэл, ном зүйд жагсаасан бүрэн ишлэлээр дамжуулан өгөх ёстой бөгөөд ашигласан системээс үл хамааран хамгийн бага шаардлагыг хангасан байх ёстой.

Суралцагч нь судалгааны эсээ бичих явцдаа нарийвчилсан лавлагаа, номзүйн жагсаалт гаргах чадвараа боловсронгуй болгохыг эрмэлзэх ёстой. Судалгааг ийм байдлаар баримтжуулах нь амин чухал зүйл бөгөөд уншигчдад нотлох баримтыг өөрсдөө үнэлэх боломжийг олгодог бөгөөд ашигласан эх сурвалжуудын ач холбогдлын талаарх суралцагчийн ойлголт мэдлэгийг харуулдаг.

Энэхүү шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд сурлагын шударга журмын зөрчил гэж үзэх тул АйБи хөтөлбөрийн дүрэм журмыг зөрчсөнтэй адилтгаж үзнэ.

Сурлагын шударга байдлын зөрчил гаргахаас зайлсхийхийн тулд сурлагын шударга байдлын талаарх мэдээллийг судалгааны эсээний гарын авлагын 84–88-р хуудаснаас болон манай сургуулийн вебсайтаас журам гэсэн хэсгээс сурлагын шударга байдлын журмыг уншиж танилцахыг зөвлөж байна.

Судалгааны эсээний үнэлгээ

Судалгааны эсээний үнэлгээний шалгуур үзүүлэлтийн тойм:

Шалгуур А: чиглэл ба арга зүй	Шалгуур В: мэдлэг ба ойлголт	Criterion C: шүүмжлэлт сэтгэлгээ	Criterion D: илтгэл	Criterion E: оролцоо
<ul style="list-style-type: none">• Сэдэв• Судалгааны асуулт• Арга зүй	<ul style="list-style-type: none">• Агуулга• Судлагдахууны онцлог нэр томьёо	<ul style="list-style-type: none">• Судалгаа• Дүн шинжилгээ• Хэлэлцүүлэг ба үнэлгээ	<ul style="list-style-type: none">• Бүтэц• Ерөнхий зураглал	<ul style="list-style-type: none">• Явц• Судалгааны чиглэл
Оноо	Оноо	Оноо	Оноо	Оноо
6	6	12	4	6

Шалгуур А: Чиглэл ба арга зүй

Энэ шалгуур нь сэдэв, судалгааны асуулт, арга зүйд төвлөрдөг. Судалгааны гол зорилго (үүнд сэдэв ба судалгааны асуулт орно), судалгааг хэрхэн яаж хийх, эсээний туршид асуудалд хэрхэн төвлөрөх талаарх тайлбарыг үнэлдэг.

Шалгуур Б: Мэдлэг ба ойлголт

Энэхүү шалгуур нь судалгааны ажлын асуултыг судлахад ашигласан сэдэв/салбар хэр зэрэг хамааралтай болохыг, эсвэл дэлхий судлалын судалгааны эсээний хувьд дэвшүүлсэн асуудал ба хоёр салбарын хэтийн төлөвийг ашигласан, мөн энэ мэдлэг, ойлголтыг зохих нэр томъёо, агуулга ашиглан харуулсан арга замыг үнэлдэг.

Шалгуур С: Шүүмжлэлт сэтгэлгээ

Энэхүү шалгуур нь тухайн судалгаанд дүн шинжилгээ хийх болон үнэлэхэд шүүмжлэлт сэтгэлгээний чадварыг хэр зэрэг ашигласныг үнэлдэг.

Шалгуур D: Бичвэр

Энэхүү шалгуур нь илтгэл нь академик бичгийн хувьд тогтсон стандарт форматыг дагаж мөрдөж байгаа байдал ба үр дүнтэй холбоо харилцаанд хэр зэрэг өгөөжтэй болохыг үнэлдэг.

Шалгуур E: Оролцоо

Энэхүү шалгуур нь судалгааны чиглэл, судалгааны явцтай холбоотой оролцоог үнэлдэг.

Ерөнхий шалгуурын хянах хуудас

Суралцагч бөглөж, судалгааны эсээний зааварлагчаар хянуулна.

Суралцагч:

Зааварлагч:

Огноо:

Асуулт	Тийм/Үгүй
1. Миний судалгааны эсээний оршил, үндсэн хэсэг, дүгнэлт нь 4000 үгтэй байна уу?	
2. Судалгааны эсээний зургаан бүрэлдэхүүн хэсэг (гарчгийн хуудас, агуулгын хуудас, оршил, эсээний үндсэн хэсэг, дүгнэлт, ашигласан материал, номзүйн жагсаалт) байна уу?	
3. Бүх хуудсыг дугаарласан уу?	
4. Бүх зураг тайлбартай юу?	
5. Бүх ишлэл ижил бөгөөд зөв хэлбэрээр байна уу?	
6. Ном зүйд таны ашигласан бүх эх сурвалж багтсан уу?	
7. Таны судалгааны асуулт гарчгийн хуудас, оршил, дүгнэлт дээр бичигдсэн байна уу?	

Судалгааны эсээний үнэлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны эсээний гарын авлагын 92-108-р хуудаснаас үзнэ үү.

Судалгааны эсээ/Мэдлэгийн онолын онооны матриц

Ерөнхий журмын 13.2-т заасны дагуу:

“АйБи дипломыг дараах бүх шаардлагыг хангасан горилогчид олгоно.

- a. CAS-ийн шаардлагыг хангасан байх.
- b. Горилогчийн оноо 24 ба түүнээс дээш байх.
- c. Мэдлэгийн онол, судалгааны эсээ, эсвэл хамааралтай хичээлд “N” үнэлгээ аваагүй байх.
- d. Мэдлэгийн онол болон судалгааны эсээ дээр E үнэлгээ аваагүй байх.
- e. Аливаа хичээл /түвшинд 1 үнэлгээ аваагүй байх.
- f. Хоёроос дээш 2 үнэлгээ аваагүй байх (HL эсвэл SL аль алинд).
- g. Гурваас дээш 3 ба түүнээс бага үнэлгээ аваагүй байх (HL эсвэл SL аль алинд).
- h. Горилогч HL хичээлүүдэд 12 ба түүнээс дээш оноо авсан байх (дөрвөн HL хичээл бүртгүүлсэн горилогчийн хувьд хамгийн өндөр гурван үнэлгээг тооцно).
- i. Горилогч SL хичээлүүдэд 9 ба түүнээс дээш оноо авсан байх (хоёр SL хичээл бүртгүүлсэн горилогчийн хувьд SL дээр хамгийн багадаа 5 оноо авсан байх ёстой).
- j. Горилогч нь АйБи хөтөлбөрийн үнэлгээний төвөөс сурлагын зөрчил гаргасан шийтгэл авч байгаагүй байх ёстой.

Ерөнхий журмын 12 дугаар зүйлд дүнгийн тухайд "АйБи дипломын хувьд Мэдлэгийн онол ба Судалгааны эсээг хослуулан гүйцэтгэсэн тохиолдолд дээд тал нь 3 оноо өгнө" гэж бичсэн байдаг.

Илүү ойлгомжтой байлгах үүднээс Судалгааны эсээ/Мэдлэгийн онолын онооны матрицыг оруулав:

ТОК/ЕЕ	A	B	C	D	E
A	3	3	2	2	Тэнцээгүй
B	3	2	2	1	
C	2	2	1	0	
D	2	1	0	0	
E	Тэнцээгүй				

Ашигласан материалын жагсаалт

Т.Ханджав. (2020), сурагчдад зориулсан СУДАЛГААНЫ ЭСЭЭ ГАРЫН АВЛАГА

Т.Ханджав. (2020), эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан СУДАЛГААНЫ ЭСЭЭ ГАРЫН АВЛАГА

Т.Ханджав. (2020), багш болон зааварлагч нарт зориулсан СУДАЛГААНЫ ЭСЭЭ ГАРЫН АВЛАГА